

МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/519

Номгон

「Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний
нэмэлт өөрчлөлтөд тусгагдаж хийгдсэн ажлыг
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1."а", 29.1.2."б" тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 3/12 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлт"-д тусгагдсан бусад эх үүсвэрээр санхүүжиж буй төслүүдийн бүтээн байгуулалтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Энхбаяр- Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч

Гишүүд:Б.Наранбаяр- Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Отгонтөгс- Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

А.Дорж- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Зам, тээврийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Б.Намуун- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхай хариуцсан мэргэжилтэн

С.Хүрэлхуяг- Аймгийн Ерөнхий архитектур

Л.Доржханд- Орон нутгийн өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Г.Баатартогтох- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Н.Пүрэвжаргал- Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Захирагчийн ажлын албаны дарга

60110197

2.


Т.Отгонбаатар- “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дарга
Иргэний төлөөлөл
Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Т.Хишигбаатар- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

2.Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлтөд тусгагдсан бүтээн байгуулалтын ажлуудыг холбогдох хууль, журмын дагуу хүлээн авч, тухай бүрт нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн, орон нутгийн өмчид бүртгүүлэн эзэмшигчийг томилох шийдвэр гаргуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Г.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

3. Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлтөд тусгагдсан бүтээн байгуулалтын ажлуудыг хүлээж авах ажлын хэсэг ажиллах бүрт олон нийтэд танилцуулан ил тод, үнэн зөв мэдээллээр хангаж ажиллахыг Хэвлэл мэдээллийн албанд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуй, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАР А  Д.МӨНХСАЙХАН